ИХ НАЯД АУДИТ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙНХЯНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ЭМ ЭЙ ЭФ ББСБ” ХХК

АУДИТЫН КОД: СТА-ББСБ-26/62
2025 ОНЫ 12 САРЫН 31

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
River Castle Business apartment
624 тоот Утас: +976 9907-7062,
И-мэйл: audit@ikhnayad.mn

Агуулга

1. Аудитын тайлан дүгнэлт хүргүүлэх тухай
2. Хараат бус аудиторын тайлан, дүгнэлт
3. Аудитлагдсан санхүүгийн тайлан
4. Оршил
5. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага
6. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт
7. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин
8. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ
9. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал
10. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
11. Аудитын явцад хийсэн залруулга, алдаа зөрчлийн талаарх мэдээлэл
12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга
14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НБЁЗОУСЗ	Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

ИХ НАЯД АУДИТ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙНХЭЛТЭН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА
Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, River Castle Business Apartment 605 тоот,
Утас: +976 99077062, 9666-4168
И-мэйл: audit@ikhnayad.mn

2026.03.25 № СТА-ХХК-26/62

ЭМ ЭЙ ЭФ ББСБ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.САНДАГДОРЖ ТАНАА

Аудитын тайлан, дүгнэлт хүргүүлэх тухай

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК болон "ИХ НАЯД АУДИТ" ХХК-ийн хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн "ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг шалгаж санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүллээ.

Энэхүү аудитын тайлан, дүгнэлттэй танилцаж, эдгээртэй холбоотой асууж тодруулах зүйл байвал бид тайлбарын хамт санал бодлоо хуваалцахад бэлэн байна.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ:.....Х.АРИУНЗУЛ

СТА-ХХК-26/62

ИХ НАЯД АУДИТ
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙНХЭЛТЭН
ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН
ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА
Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, River Castle Business Apartment 605 тоот,
Утас: +976 99077062, 9666-4168
И-мэйл: audit@ikhnayad.mn

2026.03.25 № СТА-ХХК-26/62

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Бид "ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК (цаашид "компани" гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр **"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн** 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг харицулага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

ИХНАЯД АУДИТ ХУУДАСНЫ ДУГААР ..... 2 .....

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох, эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах, компанийн чадамжийг үнэлэх, тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Аудитор нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 95 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

"ИХ НАЯД АУДИТ" ХХК

ЗАХИРАЛ ..... Х.АРИУНЗУЛ

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны **03** сарын **25**

СТА-ХХК-26/62

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК

БАЛАНС
2025 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,070,507,010.48	2,462,352,833.99
Зээл	631,144,873.58	375,680,859.87
Факторингийн тооцооны авлага	-	-
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалт	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	844,289,864.76	595,505,155.39
Санхүүгийн хөрөнгийн дүн	**8,545,941,748.82**	**3,433,538,849.25**
Татвар, НДШ-ийн авлага		
Үндсэн хөрөнгө	7,324,886.63	3,187,337.76
Биет бус хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад санхүүгийн бус хөрөнгө	-	-
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**7,324,886.63**	**3,187,337.76**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**8,553,266,635.45**	**3,436,726,187.01**
ӨР ТӨЛБӨР		
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	-	-
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-	-
Бусад эх үүсвэр	-	-
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	-	-
Бусад санхүүгийн өр төлбөр	86,222.00	4,586,222.00
Хоёрдогч өглөг	-	-
Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**86,222.00**	**4,586,222.00**
Татвар, НДШ-ийн өр төлбөр	38,705,516.98	25,658,024.12
Нөөц /Болзошгүй өр төлбөр /	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	-
Бусад санхүүгийн бус өр төлбөр	-	-
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**38,705,516.98**	**25,658,024.12**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**38,791,738.98**	**30,244,246.12**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	6,019,269,000.00	2,500,000,000.00
Өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	2,495,205,896.47	906,481,940.89
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	**8,514,474,896.47**	**3,406,481,940.89**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	**8,553,266,635.45**	**3,436,726,187.01**

- -

ББСБ ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР.....5.....

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2025 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ХҮҮГИЙН ОРЛОГО		
Банканд байршуулсан хөрөнгийн	-	-
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	-	-
Зээлийн	-	-
Үнэт цаасны	-	-
Бусад	969,918,218.90	322,100,551.75
(Хүүгийн орлогын буцаалт)	-	-
Хүүгийн орлогын дүн	**969,918,218.90**	**322,100,551.75**
ХҮҮГИЙН ЗАРДАЛ		
Итгэлцлийн үр шим	-	-
Зээлийн	-	-
Үнэт цаасны	-	-
Бусад	325,395,233.35	325,961,466.74
(Хүүгийн зардлын буцаалт)	-	-
Хүүгийн зардлын дүн	**325,395,233.35**	**325,961,466.74**
Хүүгийн цэвэр орлого	**644,522,985.55**	**(3,860,914.99)**
Эрсдэлийн сангийн зардал	38,285,338.00	1,250,030.75
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	**606,237,647.55**	**(5,110,945.74)**
БУСАД ОРЛОГО	**36,062,265.76**	**138,404,987.65**
Хүүгийн бус орлого	36,062,265.76	138,404,987.65
Бусад орлого, олз	-	-
БУСАД ЗАРДАЛ	**38,322,374.85**	**220,513,506.10**
Хүүгийн бус зардал	38,322,374.85	220,513,506.10
Бусад зардал, гарз	-	-
Татварын өмнөх ашиг, алдагдал	**603,977,538.46**	**(87,219,464.19)**
Орлогын татварын зардал	97,080,218.19	6,298,595.39
Татварын дараах ашиг, алдагдал	**506,897,320.27**	**(93,518,059.58)**
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	**506,897,320.27**	**(93,518,059.58)**
Бусад дэлгэрэнгүй орлого		
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн	**506,897,320.27**	**(93,518,059.58)**

ҮЦЭГ НХ НААД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР ..... 6 .....

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний сан	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Бусад хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	**6,019,269,000.00**	-				-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-					-	
Залруулсан үлдэгдэл	**6,019,269,000.00**	-	-	-	-	**1,988,308,576.20**	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт							
Өмчид гарсан өөрчлөлт						-	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү							
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз							
Тайлант үеийн цэвэр ашиг:						506,897,320.27	506,897,320.27
Хуваарилсан ногдол ашиг							
Хувьцаат капиталын өсөлт							
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	**6,019,269,000.00**					**2,495,205,896.47**	**8,514,474,896.47**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,519,269,000.00)						**(3,519,269,000.00)**
Залруулсан үлдэгдэл	**2,500,000,000.00**	-	-	-	-	**2,495,205,896.47**	**4,995,205,896.47**
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт							-
Өмчид гарсан өөрчлөлт	-				-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү							-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз							-
Тайлант үеийн цэвэр ашиг:						(93,518,059.58)	(93,518,059.58)
Хуваарилсан ногдол ашиг						(1,495,205,896.00)	(1,495,205,896.00)
Хувьцаат капиталын өсөлт							-
2025 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	**2,500,000,000.00**	-	-	-	-	**906,481,940.89**	**3,406,481,940.89**

ҮНЭЭСЭ ИХ НАЯД АУДИТ
ХУУДасны дугаар ..... 7 .....

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 он 12 сарын 31-ны үлдэгдэл

	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	-	-
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан хүлээн авсан	-	-
Факторингийн үйл ажиллагаанаас хүлээн авсан	-	-
Бусад	1,986,027,318.27	742,635,613.20
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**1,986,027,318.27**	**742,635,613.20**
Олгосон зээл	-	-
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	-	-
Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан буцаан шилжүүлсэн	-	-
Факторингийн үйл ажиллагаагаар шилжүүлсэн	-	-
Ажиллагсдад олгосон	-	-
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Бусад	428,874,557.38	5,345,876,283.59
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**428,874,557.38**	**5,345,876,283.59**
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**1,557,152,760.89**	**(4,603,240,670.39)**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛ	-	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	-	-
Үнэт цаас борлуулснаас хүлээн авсан	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-

ИНЭС ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР .... 8 .....

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан	-	2084652638.50
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	10,000,000.00	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	**10,000,000.00**	**-**
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	-	-
Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-
Бусад	3,674,834.00	4,913,506.10
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**3,674,834.00**	**4,913,506.10**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**6,325,166.00**	**(4,913,506.10)**
Валютын ханшийн зөрүү		-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**1,563,477,926.89**	**(4,608,154,176.49)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**5,507,029,083.59**	**7,070,507,010.48**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**7,070,507,010.48**	**2,462,352,833.99**

ИНЭЗ ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР ....9.....

Аудитын тайлан

1. Оршил

“ЭМ ЭЙ ЭФ ББСБ” ХХК (цаашид үйлчлүүлэгч гэх)-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг үйлчлүүлэгч компанийн Захирал **Д.САНДАГДОРЖ** танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Мөн аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу үйлчлүүлэгч болон “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн хооронд байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний гэрээ /хэлцэл/-г үндэслэн “ЭМ ЭЙ ЭФ ББСБ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайланг шалгаж аудит хийлээ.

Үйлчлүүлэгчийн 2025 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын батлсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Үйлчлүүлэгчийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын батлсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн чанарын хяналтын менежер **Х.Ариунзул** чанарын хяналтыг хийж, аудитор **М.Энхтуул**, туслах аудитор **Э.Цэгмид** нар хариуцаж хэрэгжүүлэв.

3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан “ИХ НАЯД АУДИТ” ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Аудитын тухай хууль болон санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд батлсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Аудитын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

ИНЭЙ ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР ..... 10 .....

4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн талаарх ерөнхий мэдээлэл:

- Регистрийн дугаар: ***5617375***
- Үйл ажиллагааны чиглэл:

Д/д	Үйл ажиллагааны код	Үйл ажиллагааны чиглэл
1	6630	Зээлийн үйл ажиллагаа

- Харилцдаг санхүү, татварын байгууллага***: Хан-Уул дүүргийн Татвар болон Санхүү, Төрийн сангийн хэлтэс***
- Захирал (эзэн)-ын нэр: ***Дашдорж Сандагдорж***
- Ерөнхий нягтлан бодогчийн нэр:
- Хаяг: ***Улаанбаатар хот, Хан-Уул, 15-р хороо, зайсан, гэгээнтэн хотхон 202 байр 2 давхар 202 тоот***

  Санхүүгийн тайлан хүргүүлж ирсэн огноо: **2026.03.02**

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Үндсэн хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Аудитын тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Үйлчлүүлэгч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үйлчлүүлэгч байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

ИНЭС ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР ..... 11 .....

6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АОУС-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн хэмжээг сонгов.

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн 2025 оны нийт хөрөнгө **3,436,726.2** мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох **34,367.3** мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь уламжлалт болон хяналтын эрсдлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

8. Аудитын явцад хийсэн залруулга, алдаа зөрчлийн талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын залруулсан алдаа болон шийдвэрлэсэн зөрчилтэй асуудал ажиглагдаагүй болно.

9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудалгүй байна.

10. Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК нь тайлант хугацаанд нийт **322,100.6** мянган төгрөгийн хүүгийн орлоготой, **325,961.5** мянган төгрөгийн хүүгийн зардалтай ажиллаж, тайлант хугацаанд **1,250.0** эрсдлийн сангийн зардал гарч, **93,518.1** мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

11. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид **"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК**-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын дүгнэлтэд тодорхой дурдав.

ИНС ИХ НАЯД АУДИТ
ХУУДасны дугаар ..... 12 .....

Аудиторын дүгнэлт гаргахдаа үйлчлүүлэгч байгууллагын бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

Санхүүгийн тайланг шалгасан:

"ИХ НАЯД АУДИТ" ХХК-ийн

Аудитор:
..... / **М.Энхтуул** /

Аудиторын туслах:
..... / **Э.Цэгмид** /

Утас: +976 9907-7062, 9666-4168
И-мэйл: audit@ikhnaya.mn

Үйлчлүүлэгч байгууллага:

"ЭМ ЭЙ ЭФ ББСБ" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал:
..... / **Д.Сандагдорж** /

Нягтлан бодогч:
..... / **М.Олонбаяр** /

Утас: +976 9908-0497
И-мэйл: olonbayar.fides@gmail.com

СТА-ББСБ-26/62

ИНАС ИХ НАЯД АУДИТ
ХУУДАСНЫ ДУГААР ..... 13 .....